

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо :2016 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хяналтын камер суурилуулах ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧДХААА А16/0017**

**Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хяналтын камер суурилуулах ажил”**-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг **100.000** (нэг зуун мянган) төгрөгөөр худалдан авч болно.

Төлбөрийг Чингэлтэй Төрийн сан банкин дахь: ЧД Тендерийн баримт бичиг 200751009 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:**

*Сүүлийн 2 жил / 2014, 2015/-ийн дундаж борлуулалт нь 200.000.000 /хоёр зуун сая/ төгрөгөөс багагүй байх*

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:**

*86.000.000/наян зургаан сая/ төгрөгөөс багагүй байна.*

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:**

*2014, 2015 оны санхүүгийн жилийн эцсийн тайлан /алдагдалгүй ажилласан байх/*

**Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй нэг ажлын өртөг:**

*Сүүлийн 2 жилд буюу 2014, 2015 онд ядаж нэг удаа санал болгож байгаа үнийн дүнгийн 50 хувиас доошгүй үнийн дүнтэй гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх*

**Шаардлагатай тусгай зөвшөөрөл:**

Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгодог:

*“Б” ангилал: Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл*

Тендерийн хамт 5.700.000 /таван сая долоон зуун мянган/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16,  
Нийслэлийн Нутгийн захирагааны байгууллагуудын II дугаар байр. Чингэлтэй дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын байр. Худалдан авах ажиллагааны алба 206 тоот өрөө  
Утас : 70110769*